



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/578


Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах,
зардал гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9, 8.1.23 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.12 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6.4.1, 14.2.3, 14.2.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2014 оны 119 дүгээр тушаалаар баталсан “Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам”-ын 1.5 дахь заалт, Сангийн сайдын “Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” 2011 оны А/188 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 21 аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа 9 дүүргийн эрүүл мэндийн төв, амаржих газар, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн удирдах түвшний менежрүүдийг чадавхижуулах сургалтыг Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулсугай.
2. Удирдах ажилтнуудын гадаад сургалтыг хариуцлагатай зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирал /Б.Нарантуяа/-д даалгасугай.
3. Гадаад сургалтад шаардагдах зардлыг энэ онд батлагдсан төгсөлтийн дараах сургалтын зардлаас гаргахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирал /Б.Нарантуяа/-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Я.Амаржаргал/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

082220